

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТОГТОЛЦООГ ТАЙЛБАРЛАХ ОНОЛ, ХАНДЛАГУУД

Б. Бат-Өлзий
Доктор (Ph. D.)

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

bbatulzii04@gmail.com

Б. Болормаа
Доктор (Ph. D.), хөтөлбөр хариуцсан дэд профессор

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

bumbaalai8888mn@yahoo.com

Хураангуй: *Нийгмийн халамжийн тогтолцоог тайлбарлах олон арван онол, үзэл баримтлал, урсгал чиглэл, хандлага, загварууд нийгмийн шинжлэх ухааны мэдлэгийн санд нэгэнт бий болжээ. Тиймээс тэдгээрийг эмх цэгцтэй, товч тодорхой, бүтээлчээр авч ашиглах шаардлага тулгарч байгаа юм.*

Уг өгүүлэлд 1-рт нийгмийн халамж нь нийгмийн бүтцийн тогтолцоонд чухал байр суурь, функц бүхий элемент, дэд систем болох хувьдаа Функционал онол ба Системийн онолуудаар хэрхэн тайлбарлагдах боломжтойг, 2-рт Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох арга зүйн асуудлыг сэтгэл судлал, социологийн шинжлэх ухаанд боловсорч, хожмоо нийгмийн ажлын практикт өргөн хэрэглэгдэх болсон зарим онолуудаар тайлбарлахыг зорилоо.

Түлхүүр үгс: *Функциональ онол, халамжийн систем, халамжийн сөрөг функц, зорилтот бүлэг*

ҮНДСЭН ХЭСЭГ

Нийгмийн халамжийн онолын эх үндэс нь гуманист хандлага мөн боловч нийгмийн практик хэрэглээний хувьд илүү позитивист шинжтэй билээ. Өөрөөр хэлбэл нийгмийн халамж нь эмпирик байдлаар хэмжигдэхүйц, объектив үзэгдэл юм. Тиймээс нийгмийн халамжийг тайлбарлах онол арга зүйг нийгмийн баримт сэлтийн парадигмын тулгуур онолуудын хүрээнд авч үзэж болно. Нийгмийн халамж нь нийгмийн бүтцийн тогтолцоонд чухал байр суурь, функц бүхий элемент, дэд систем болох хувьдаа Функционал онол ба Системийн онолуудаар тайлбарлагдах боломжтой.

Функционал онол (Functionalism): Функционал онолын төлөөлөгчид нь О.Конт, Э.Дюркгейм, Р.Браун, Б.Малиновский, Т.Парсонс, Р.Мертон нар юм. Социаль үйл явдлыг функц (үүрэг)-ийнх нь талаас буюу тэдгээрийн нийгэмд үзүүлэх нөлөөллөөр нь хамгийн сайн тайлбарлаж болно гэх төсөөлөлд үндэслэгдсэн онолын чиглэл. Функционал онолын суурийг тавьсан О.Конт Нийгмийн статик байдлын тухай сургаальдаа гэр бүл, шашин, төр гэсэн 3 институтын функцыг тодорхойлсон байдаг. О.Конт эдгээр 3 институтыг нийгмийн зөвшлийг бий болгож, хадгалж, интегралчлалыг дэмжин тэтгэж байдаг үүрэгтэй гэж үзсэн.

Ямар нэгэн нийгмийн үйл ажиллагаа эсвэл институтын функцыг судлана гэдэг нь бүхэл нийгмийн тогтолцооны оршин тогтноход түүний оруулж буй хувь нэмэрийг судлана гэсэн үг юм¹².

Тиймээс функционал онолын үүднээс асуудлыг авч үзвэл Монголын нийгмийн тогтолцооны оршин тогтнолд нийгмийн халамжийн гүйцэтгэж буй үүргийг тодруулан авч үзнэ гэсэн үг. Нийгмийн халамж нь нийгмийн хамгааллын институцийн бүрэлдэхүүнд орших дэд систем бөгөөд ядуурлыг бууруулах, хүн амын эмзэг хэсэгт орлогыг дахин хуваарилах, тэгш бус байдлыг багасгах, өрх гэр бүлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тэднийг эрсдлээс хамгаалах, нийгмийн бусад салбарыг халамжлах болон асрамжлах үүргээс чөлөөлөх, ингэснээр тэдгээр бусад салбарууд өөрсдийн чиглэлийн үйл ажиллагаанд анхаарал хандуулах боломжтой болдог зэрэг олон зэрэг үүргийг нийгэмд гүйцэтгэдэг. Ингэснээрээ нийгмийн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн хөгжил цэцэглэлтэнд томоохон түлхэц үзүүлдэг.

Р.Мертон ил болон далд /латент/ функцийн өөр хоорондоо ялгагдах ялгааг тодорхойлсон. Ил функц гэж тодорхой нийгмийн үйл ажиллагааны хэв шинжид оролцож буй оролцогчдын мэдэж, тооцож буй зүйлийг хэлдэг бол латент функц гэдэг нь дээрх оролцогчдын урьдчилан мэдээгүй, санаагүй үр дагавар ажээ¹³. Жишээлбэл 2017 оны 1-р сард Монгол Улсын ЗГ-аас тэтгэврийн зээлийн хүүг бууруулах шийдвэр гаргасан. Энэ нь ахмад настнуудын нийгмийн хамгааллын чухал ач холбогдолтой арга хэмжээ мөн боловч, ахмад настнууд буюу тэтгэврийн насны аав ээжийнхээ нэр дээр үр хүүхдүүд нь зээл авах байдал газар авсан нь урьдчилан хараагүй далд нөлөөлөл болж гарч ирж байна.

Түүнчлэн Р.Мертон функц дотор сөрөг функц буюу дисфункц гэсэн ойлголт бий гэж үзсэн. Тэрээр орчин цагийн нийгмийг судлахдаа эв нэгдлийг сарнин бутаргадаг хандлагыг мөн тооцох шаардлагатай. Сөрөг функц гэсэн ойлголт бол нийгмийн нэгдэл нягтралд заналхийлж буй

¹² Гидденс.А. (2006) Социологи, УБ

¹³ Merton R. (1957) *Social Theory and Social Structure*. Glencoe

нийгмийн үйл ажиллагааг судлахтай холбоотой ажээ. Нийгмийн үйл ажиллагааны сөрөг функцийг судлана гэдэг нь юмс үзэгдлийн оршин буй эмх цэгцэд заналхийлж буй нийгмийн амьдралын шинж талуудыг судлана гэсэн үг юм¹⁴. Энэ талаас авч үзвэл нийгмийн халамжийн сөрөг тал буюу үүргийг авч үзэх, тооцох шаардлага гарч ирнэ. Үнэхээр ч нийгмийн халамж нь бүх талаар өв тэгш, нийгэмд дандаа сайн сайхан зүйл авч ирдэг гэж туйлширч болохгүй. Түүнд сул тал буюу нийгэмд үзүүлдэг дарамт, сөрөг функцүүд байдаг. Тухайлбал нийгмийн халамж нь ямар нэг байдлаар хүмүүсийн зан үйлд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг. Зарим тохиолдолд нийгмийн халамж нь бэлэнчлэх сэтгэлгээ бий болгох, байнгын ядууралд байх сонирхол, эрх ашиг бий болгох, хувь хүний чадавхийг сулруулах, идэвхигүй сул дорой байдлыг дэмжих нөхцлүүдийг бий болгодог. Нийгмийн тогтолцооны үүднээс авч үзвэл нийгмийн халамж нь татварын мөнгөөр санхүүждэг учраас эдийн засаг, бизнес, санхүү, үйлдвэрлэлийн салбарт тодорхой хэмжээний дарамтыг учруулж байдаг. Тиймээс нийгмийн халамжийн эдгээр сөрөг функцийг хамгийн бага түвшинд буюу зохист хэмжээнд байлгахад зайлшгүй анхаарах ёстой бөгөөд Р.Мертонь дисфункцин талаарх ойлголт нь бидэнд ийм сэрэмжлүүлэгийг өгч байгаагаараа ач холбогдолтой юм.

Нийгмийн халамжийн түвшинд социологийн шинжлэх ухааны онолын парадигмууд, тэдгээрийн тулгуур онолууд тун чухал үүрэгтэй юм. Жишээлбэл нийгмийн баримт сэлтийн парадигмын тулгуур онол бүтэц-функционализм нийгмийн халамжийн олон талт дүр ба функцийг тодорхойлж, тайлбарлахын сацуу үйлчлүүлэгчийн зан үйл, үйлдэлд нийгмийн томоохон бүтцүүдийн үзүүлэх нөлөөллийн хүчин зүйлийг тооцон үзэх боломж олгодог байна. Түүнчлэн нийгмийн ажлын макро түвшний нөлөөллийн хувьд нийгмийн дэд системүүд болон социеталь системийг ойлгох боломж олгож, нийгмийн халамжийн үйлчилгээний эрх зүйн орчин, институцэжсэн байдал, сонирхогч талуудын байр суурийг боловсронгуй болгохуйц бодлого боловсруулахад нөлөөлөх бололцоог бүрдүүлж байгаа юм¹⁵ гэж судлаач О.Мөнхбат үзсэн байна.

Системийн онол: Юуны өмнө системийн талаарх ерөнхий ойлголтыг товч авч үзье. Систем гэдэг нь нэгтгэх, нэг дор байрлуулах, хамтад нь авч үзэх, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгж хэсгүүдийн нийлбэр цогц гэсэн утга бүхий “systema” гэсэн грек үгнээс гаралтай. Систем гэсэн ойлголтыг хамгийн энгийнээр “Систем нь өөр хоорондоо харилцан холбоотой хэсгүүдийн олонлог” хэмээн тодорхойлж болно.

¹⁴ Гидденс.А. (2006) Социологи, УБ

¹⁵ О.Мөнхбат (2016) Нийгмийн ажилд онол хэрэгтэй юу? Социологи сэтгүүл, №11 (456), УБ

Аливаа систем нь орчинтойгоо байнга харилцан үйлчлэлцэж байдаг төдийгүй үйлчлэх орчноосоо хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Систем нь том системийн бүрэлдэхүүн хэсэг байхаас гадна өөртөө дэд хэсгүүд буюу дэд системүүдийг агуулж болно. Системийг орчноосоо хамаарах хамаарлаар нь нээлттэй ба хаалттай систем гэж хуваан үздэг. Нээлттэй систем нь өөрийн орчны нэгжүүдтэй харилцан үйлчлэлцдэг бол хаалттай систем нь орчноосоо тусгаарлагдсан байдаг. Гадаад орчинтойгоо харилцан үйлчлэлцэж буй бүх системүүд нээлттэй систем болно.

Систем нь дараах шинж чанартай. Үүнд:

- Системийг бүрэлдүүлэгч үндсэн элементүүд нь өөр хоорондоо уялдаа холбоотой, бие биенээсээ шууд болон шууд бусаар хамааралтай байна. Өөр хоорондоо ямар ч харилцан холбоогүй, хамааралгүй, бие даасан элементүүд системийг бүрэлдүүлж чадахгүй. Иймээс аливаа системийг судлахад түүнийг бүрэлдүүлэгч элементүүд, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг тодорхойлж, шинжлэх нь маш чухал;
- Систем нь хүрээлэн буй орчноосоо биет зүйл, өгөгдөл, мэдээлэл хүлээн авах оролт ба өөрийн төлөв байдлаа илэрхийлсэн гаралттай байна;
- Систем нь чиглэсэн зорилготой байна. Систем өөрийгөө бүрэлдүүлж буй өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж, бие биедээ нөлөөлж байдаг элементүүдийг тохируулан зохицуулах өөрийн дүрэм журам, зүй тогтолтой байж, зорилгоо биелүүлдэг;
- Системүүд нь өөрийгөө бүрэлдүүлэгч дэд системүүдийг агуулдаг. Том системд жижиг системүүд агуулагддаг. Эдгээр жижиг системүүд нь тухайн системийн хувьд дэд системүүд болно;
- Системийн эцсийн зорилгод цорын ганц замаар бус, хэд хэдэн замаар хүрч болно. Иймээс зорилгод хүрэх боломжит арга зам, шийдлүүдийг зөв тодорхойлж, улмаар тэдгээрээс хамгийн оновчтой арга замыг сонгох нь чухал.

Системийн талаарх дээрх ойлголтоор тайлбарлавал нийгмийн халамж нь нийгмийн хамгаалал хэмээх том системийн бүрэлдэхүүн хэсэг буюу дэд систем болж оршин тогтнохоос гадна, өөртөө нийгмийн халамжийн эрх зүй, хууль, дүрэм журам, халамжийн бодлого, удирдлагын тогтолцоо, төв ба орон нутгийн байгууллагууд, ажиллагсад, боловсон хүчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөнгөлөлт, тусламж, дэмжлэг, асрамж, сувилал гэх мэт үйлчилгээнүүд, эдгээр үйлчилгээний арга технологи, үйлчлүүлэгчид буюу зорилтот бүлгүүд (ядуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүд, ахмад настан, хүүхэд) гэх мэт дэд системүүдийг багтаасан харьцангуй бие даасан систем болно. Түүнчлэн нийгмийн халамж нь нээлттэй систем бөгөөд бусад системүүдтэй харилцан

үйлчлэлцэж, тэдэнд нөлөөлж, тэдний нөлөөлөд орж байдаг ба эдгээрийг Монгол улсад хүчийн төгөлдөр үйлчилж буй хууль дүрэм журам болон нийгмийн социаль хууль зүй тогтлууд зохицуулж байдаг. Тухайлбал нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хүн ам зүйн бодлого, улсын төсөв, санхүү, эдийн засаг, татвар, соёл, ёс заншил, уламжлал, нийгмийн ухамсар, сэтгэлгээ, ядуурлын түвшин гэх мэт асар олон системүүдтэй харилцан үйлчлэлцэж, тэдгээрт нөлөөлж, тэдгээрээс хамаарч нийгмийн халамжийн систем оршдог.

Системийн онол нь нийгмийн халамжийн бүх түвшинд хэрэглэгдэх онцлогтой. Хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийт, орон нутгийн түвшинд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний практикт төдийгүй, макро түвшинд нийгмийн тогтолцооны дэд систем болох нийгмийн халамжийн үйл ажиллагааг тайлбарлах бүрэн боломжтой онол юм. Системийн онол нь 1970-аад оноос нийгмийн ажилд хүчтэй орж ирсэн гэж үздэг. Системийн онол нь психо-динамикийн онолыг хангалтгүй гэж үзсээр нийгмийн ажлын шинжлэх ухаанд гарч ирсэн онолуудын нэг юм¹⁶.

Системийн онол нь радикал онолуудтай харьцуулахад тухайн нийгмийнхээ зохион байгуулалт, нийгмийн бодлогыг шүүмжилдэггүй. Өөрөөр хэлбэл тухайн системийнхээ зохион байгуулалтыг хүлээн зөвшөөрч, түүнд дүн шинжилгээ хийдэг болохоос түүнийг эсэргүүцдэггүй. Иймээс энэ онолыг эрх мэдлийг өөртөө агуулсан засаг төрийн бүтцэд байдаг мэргэжил, байгууллагуудад хэрэглэхэд зохимжтой¹⁷. Өөрөөр хэлбэл төрийн нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлдэг нийгмийн халамжийн системийн үйл ажиллагааг энэхүү онолоор тайлбарлахад нэн тохиромжтой юм.

Америкийн судлаач А.Пинкус, А.Минахан системийн онолыг нийгмийн халамжийн үйл ажиллагааг тайлбарлахад хэрэглэх талаар өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Тэд хамгийн нөлөө бүхий 3 төрлийн систем байдаг гэж үзсэн¹⁸. Үүнд: 1. Албан бус системүүд (гэр бүл найз нөхөд, хөршүүд гэх мэт), 2. Албан ёсны системүүд (үйлдвэрчний эвлэл, улс төрийн байгууллагууд гэх мэт), 3. Социеталь системүүд буюу социаль институтүүд (сургууль, нийгмийн халамж хамгааллын байгууллагууд гэх мэт). Тэдний үзсэнээр нийгмийн халамж нь янз бүрийн зорилго, үүрэг, арга хэрэгсэл бүхий үйлдлүүдийн цогц систем. Нийгмийн халамж нь өөрийн гэсэн зарчим, зүй тогтлуудтай байдаг аж. Системийн онолын энэхүү загварын дагуу нийгмийн халамжийн үйл ажиллагааг үе шат,

¹⁶ НХТ, НАБСХ (2003), *Үйлчлүүлэгчтэй тулж ажиллах практикийг Монголын нийгмийн ажилд томъёолох нь. Нийгмийн Ажлын багш сургагчдын Олон улсын зуны сургалтын материал*

¹⁷ Payne (1997) *Modern Social Work Theories. 2nd ed. Macmillan Pres. London*

¹⁸ Пинкус А. Минахан А. (1993) *Практика социальной работы (форма и методы), Москва*

хэсгүүдэд задлан, тухайн үе шат хэсэг болгонд хэрэгжүүлэх ёстой ажил, ажилбаруудыг тодорхойлох ёстой юм.

Социологийн томоохон төлөөлөгч Т.Парсонс нийгмийг систем болох талаас нь өөрөөр хэлбэл системийн хандлагын үүднээс тайлбарлах асуудлыг авч үзсэн. Т.Парсонсын нийгмийн тогтолцооны гол асуудал бол нийгмийн эмх цэгцийн асуудал гэж үзсэн ба системийн гол, суурь шинж чанар бол түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал аж. Харилцан хамаарал гэж системийн элементүүдийн хоорондох харилцааны журамлагдсан байдлыг хэлнэ.

Т.Парсонс аливаа системийн шинж чанарыг дараах байдлаар тодорхойлсон байна. Түүний үзсэнээр систем нь:

- Системийн хэсгүүд нь өөр хоорондоо харилцан хамааралтай, эмх цэгцтэй байна;
- Систем нь тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах чадвартай байдаг;
- Систем нь статик тогтвортой байдлыг хадгалахын сацуу эмх цэгцтэй өөрчлөлтөнд орох чадвартай байна;
- Системийн нэг хэсгийн мөн чанар нь нөгөө хэсгүүддээ нөлөө үзүүлэх чадвартай байдаг;
- Систем нь хүрээлэн байгаа орчноосоо зайгаа барьж, хил хязгаараа хадгалдаг;
- Хуваарилалт ба интегращлал нь системийн тэнцвэртэй байдлыг хадгалах суурь үндсэн үйл явц юм;
- Систем нь орчноос зайгаа хадгалах, бүхлийн хэсгүүдтэй харилцаанд орох, өөрчлөлтөнд орох хандлага хийгээд хүрээлэн буй орчны олон талт байдлыг хянах чадвартай байдаг¹⁹.

Т.Парсонсын дээрх тайлбарлалын хүрээнд МУ-ын нийгмийн халамжийн системийн өнөөгийн байдлыг шинжлэн үзвэл сонирхолтой үр дүн гарна. Тухайлбал манай улсын нийгмийн халамжийн системийн хэсгүүд өөр хоорондоо хэр зэрэг харилцан хамааралтай, эмх цэгцтэй байна, халамжийн систем тогтвортой тэнцвэртэй байдлаа хадгалж чадаж байна уу, эмх цэгцтэйгээр өөрчлөлтөнд орох чадвартай юу, хүрээлэн байгаа орчинтойгоо хэр зэрэг зайгаа барьж хил хязгаараа хадгалдаг гэх мэт олон асуултууд урган гарч ирж байна.

Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох арга зүйн онолын үндэс: Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох арга зүйн асуудлыг сэтгэл судлал, социологийн шинжлэх ухаанд боловсорч, хожмоо нийгмийн ажлын практикт өргөн хэрэглэгдэх болсон зарим онолуудаар тайлбарлахыг зорилоо.

¹⁹ О.Мөнхбат (2008) Социологийн онол, УБ

Давхраажилтын онол. Нийгмийн халамжийн зорилтот бүлгүүд нь амьжиргааны түвшний ялгаатай байдлаараа нийгмийн давхраажилтын тогтолцоонд байрших учраас Нийгмийн давхраажлын онолоор тайлбарлагдах бүрэн боломжтой. Уг онол нь нийгмийн гишүүдийг янз бүрийн шалгуураар дээд, дунд, доод давхрага буюу ангиуд хуваадаг. Судлаачид нийгмийн гишүүдийг давхраанд хуваах янз бүрийн шалгуурууд санал болгодог ч **“өмч хөрөнгө, эд баялаг эзэмших байдал”** гэсэн шалгуур хамгийн нийтлэг гол шалгуур байдаг. Түүнчлэн **боловсрол, эрхэлж буй ажил хөдөлмөр** зэрэг нь давхраажилтын нөлөө бүхий шалгуурууд болно. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг давхраажилтын онолын үүднээс авч үзвэл хамгийн доод давхаргын хэсэг буюу эд баялаг, өмч хөрөнгө муутай, ядуу, боловсрол багатай, ажил хөдөлмөр эрхэлдэггүй хэсэг юм. Өөрөөр хэлбэл нийгмийн халамжийн зорилтот бүлэг гэдэг нь давхраажилтын онолын үүднээс доод ангид багтах өрх иргэд юм.

Монгол улсад шинээр нэвтрүүлэхээр зорьж буй нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох ООГА-ын гол үзэл санаа нь өрх иргэний амьжиргааны түвшинг орлогоор тодорхойлох боломжгүй нөхцөлд тухайн өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй эд хогшил, хөрөнгө болон эрхэлж буй ажил хөдөлмөр, аж ахуй, боловсролын түвшин зэрэг үзүүлэлтүүдээр дамжуулан тодорхойлж, улмаар өрхүүдийг амьжиргааны түвшингээр нь эрэмбэлэх явдал юм. Энэ нь Монгол улсын нийт өрхийг ядуугаас нь хамгийн баян чинээлэг хүртэл нь нийгмийн давхраажилтанд хувааж буй хэрэг юм. Тиймээс давхраажилтын онол нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох ООГА-ын онол, арга зүйн үндэс болох юм.

Түүнчлэн нийгмийн ажлын шинжлэх ухааны үйлчлүүлэгчтэй тулж ажиллах практикт ашиглагддаг онолууд нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох, улмаар тэдэнд нийгмийн халамжийн үйлчилгээ хүргэх арга зүйн үндэс болох юм. Тухайлбал, Америкийн эрдэмтэн Н.Коади үйлчлүүлэгчтэй тулж ажиллах практикт ашиглагдах онолуудыг 4 том ангилалд оруулсан байдаг. Үүнд: 1. Психо-динамик, 2. Танин мэдэхүй – зан үйлийн, 3. Гуманист болон феминист, 4. Нэн шинэ үеийн (postmodern) гэж ангилжээ²⁰. Ийнхүү ангилсанаар үйлчлүүлэгчтэй ажиллах практик үйл ажиллагааг тайлбарладаг өргөн хүрээтэй, олон чиглэлийн онолуудыг цэгцтэй авч үзэхэд чухал ач холбогдолтой юм. Ер нь нийгмийн ажил болон нийгмийн халамжийн практикт хэрэглэгддэг үйлчлүүлэгчтэй тулж ажиллах бүхий л онол, загварууд бүгд өөр өөрийн гэсэн давуу хийгээд сул талуудтай юм. Тиймээс эдгээр онолуудыг тухайн

²⁰ Coady, N. (2001) *Theoretical perspectives for direct social work practice*. Springer Publishing Company, New York. pp. 27-43

үйлчлүүлэгч буюу зорилтот бүлгийн хэв шинж, онцлог, тулгамдаж буй асуудал, үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлаас шалтгаалан зөв хэрэглэх ур чадвар илүү чухал билээ.

Нэг. Психодинамик онолууд: Онолын үндэс нь Австрийн сэтгэл зүйч З.Фрейдийн психоанализ юм. Психодинамик онол нь хүний бэрхшээл зовлонгийн үндэс нь хүүхэд насандаа амссан шоовдорлол, айдас, зовиур юм гэж тайлбарладаг. Ухамсарлагдаагүй дотоод зөрчил буюу өсөлт хөгжлийн үеийн гачигдал нь зан үйл, сэтгэхүй, сэтгэл мэдрэлийн согогийг үүсгэдэг гэж үздэг. Ихэнх психодинамик сэтгэл заслын гол зорилго нь ухамсарт бус түвшинг ухамсарлуулах явдал юм. Хүүхэд насных нь хүсэл мөрөөдөл, дурсамж, айдас, түгшүүр болон мэдрэмжээ ухамсарлан ойлгоход нь саад болж байсан хүчин зүйлсийг мэдрүүлэх, ойлгуулах нь чухал гэж үзнэ.

Өнгөрсөн 20-р зуунд барууны орнуудад хүчтэй дэлгэрч байсан энэ онолын загвар цэвэр байдлаараа орчин үед хэрэглэгдэхээ больсон. Сонгодог психо-анализын онолоос хойш маш олон психо-динамикийн онол салбарлан гарсан. Шинэ онолууд нийгэм болон хүмүүсийн хоорондын харилцааны нөлөөллийг ихээхэн анхаарах болсон. Психодинамик онолын хөгжилд нийгмийн хүчин зүйлийг ихэд анхаардаг, хүний оюун ухааны (ego) дасан зохицох өндөр чадвартай гэж үздэг эго-сэтгэлзүй ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Эриксон бие хүний нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн үе шатыг гаргаж ирсэн. Психодинамик онолын зарим урсгал хувь хүний хөгжилд ойр дотно хүмүүсийн харилцаа ихээхэн үүрэгтэйг тэмдэглэж байв. Эдгээр онолуудыг харилцан хамаарал – бүтцийн (relational structural) загвар нэрийн дор нэгтгэн авч үздэг. Энэ загварт харилцааны психоанализ, объектой харилцах онол, өөрийгөө ойлгох сэтгэл зүй (self psychology), бусадтай ээнэгшин дасах харилцаа нь зан авирт нөлөөлдөг талаарх Боулбигийн онол зэргийг хамруулан авч үздэг. Нэлээд сүүлд гарч ирсэн орчин үеийн шинэ хэлбэрүүдийн нэг болох түргэвчилсэн /brief/ терапи нь үргэлжлэх хугацааны хувьд богиносж, хүүхэд насанд тохиолдсон тааламжгүй дурсамжийг биш яг одоо тухайн хүний амьдралд тохиолдоод байгаа асуудлыг уг хүний дотоод сэтгэлдээ хэрхэн үзэж буйг сэтгэл заслын аргаар гаргаж ирэхийг чухалчлах болсон.

Барууны орнуудад энэ загвар бие хүний түвшинд хэрэгжүүлэх нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд зонхилон хэрэглэгддэг байсан. Энэ нь эдгээр орны хөгжлийн түүх, соёлын онцлогтой холбоотой. Капиталист онолын үзэл баримтлал нь хүний амин хувиа хичээх, өөрийгөө асуудлын төвд тавьдаг шинж чанарыг өргөмжлөхөд чиглэсэн баримжаалалтай билээ. Хувь хүн аливаа үйл ажиллагааг эрхлэхдээ өөрийнхөө л оршин тогтнол, хөгжин дэвшихийн төлөө л байдаг. Энэ л хамгийн чухал зүйл. Нийгэм, төр бүхэлдээ хувь хүмүүсийн сайн сайхны төлөө л байх ёстой. Тэдгээр нь

хувь хүнийг өөрийн эрхшээлд, эрэг шургийн байдалтай байлгах ёсгүй. Хувь хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг хангахын төлөө үйлчилдэг байх ёстой гэх мэт онолын чиг баримжаатай явж ирсэн. Нийгмийн халамжийн практик энэ үзэл номлолыг үндэс болгон хөгжиж байв. Хэдийгээр психодинамик нь ноёлох хандлага, чиг баримжаа байхаа больсон ч нийгмийн халамжийн практик үйл ажиллагаануудад тодорхой хэмжээнд агуулагдсан хэвээр байгаа билээ.

Хоёр. Танин мэдэхүй – зан үйлийн онол: Танин мэдэхүй ба зан үйлийн онолууд нь өөр өөр ангилалд ордог байсан ч Бандура, Волтер нарын дэвшүүлэн гаргасан нийгмээс суралцахуйн онол (Social learning theory) нийгмийн зан үйлийг даган дуурайх, ажиглан суралцах гэсэн шинэ нэр томъёогоор зан үйлийн онолыг баяжуулсан юм. Харин Бек (1976) сэтгэхүй, итгэл үнэмшлийн тухай тайлбарлахдаа суралцахуйн онолыг ашигласан нь танин мэдэхүйн онолын хөгжилд түлхэц болсон байна. Ийнхүү амьдралд суралцахуйн үүргийг чухалчлах болсон нь танин мэдэхүйн ба зан үйлийн онолуудыг нэг ангилалд багтаах болсон юм. Энэ чиглэлийн практик үйлчилгээ нь бусдаас сурсан буруу зан авир, зөрүү ойлголтыг засахыг эрмэлздэг. Тухайлбал ийм практик үйлчилгээг нийгмийн халамжийн зорилтот бүлэг болох хорихоос суллагдагсад үзүүлж болно.

Түүнчлэн танин мэдэхүйн ба зан үйлийн онолчид бэрхшээл хэдийгээр өнгөрсөн амьдралаас эхтэй ч одоогийн байгаа байдалд илүү анхаарах хэрэгтэй гэж үздэг. Тэд эмзэг асуудлыг өөрчлөхөд түлхүү анхаарч үйлчлүүлэгчээ өөрийгөө өөрчлөхөд нь байнга санаа тавин туслахыг эрмэлздэг. Ингэхдээ танин мэдэхүйн онолыг баримталдаг практик ажилтнууд аливаа зүйлийг сөрөг талаас нь бодоход нөлөөлдөг зуршил болсон сэтгэхүйн үйл явцыг илрүүлэн арилгахад анхаардаг байхад, зан үйлийн онолыг баримтлагчид үйлчлүүлэгчдээ нийгмийн харилцаанаас сайн зүйлийг нь таньж суралцах ур чадвар олгохыг эрмэлздэг. Танин мэдэхүйн ба зан үйлийн практикийн гол зорилго нь тодорхой эмгэг, зовлон бэрхшээлийг арилгах явдал юм. Энэ нь хүний амьдрах нөхцлийг сайжруулна гэж энэ чиглэлийнхэн үздэг. Тэд практик ажилтан ба үйлчлүүлэгчийн халуун дотно харилцаа, хамтын ажиллагаа халамжийн үйлчилгээг үр дүнтэй болгоход нөлөөтэй гэж үздэг. Энэ чиглэлийн халамжийн үйлчилгээ зан үйл ба ухамсар гэсэн тусдаа хоёр зүйл дээр суурилдаг ч, ихэнх нь энэ хоёрыг хослуулах нь үр дүнтэй гэж үздэг.

Гурав. Гуманист онолууд: Гуманист онолуудын нийтлэг талуудаас дурьдвал:

1. Яг одоо энд гэдэг зарчмыг дагаж үйлчлүүлэгчид одоо тулгараад байгаа асуудлаа өөрөө хэрхэн үнэлж байгаад түшиглэдэг;

2. Үйлчлүүлэгчийн өөрийгөө дайчлах, өсөж хөгжих чадварт нь итгэлтэй байдаг;
3. Үйлчлүүлэгч нийгмийн ажилтан хоёрын эрх тэгш хамтын ажиллагааг чухалчилдаг.

Гуманист онолын хоёр гол төлөөлөгч нь **үйлчлүүлэгч төвтэй практик** болон **оршин байхуйн** онолууд юм. Эдгээр онол хүний зовлон бэрхшээл өөрийнхөө амьдралд санаа тавихгүйгээс болдог гэж үздэг. Иймд гол арга нь өөрийн амьдралаа дүгнэж цэгнэх, амьдралаа шинэ утга агуулгатай болгоход үйлчлүүлэгчдээ туслах явдал юм. Жишээлбэл энэ онолын томоохон төлөөлөгч Греенберг, Еллоуд, Леатр нарын дэвшүүлсэн үйлчлүүлэгч төвтэй нийгмийн ажлын практик нь бусад хүмүүсийн өөрт нь хандах хандлагаас үүссэн өөрийгөө голох явдлыг өөрийгөө бодитой олон талаар дүгнэх аргаар арилгахад нь тусалдаг.

Гуманист онолууд хүний ерөнхий өсөлт хөгжилд анхаардагаараа психо-динамик онолуудтай адил ч, тодорхой эмгэг, бэрхшээл зовлонг онцлон үздэгээрээ ялгаатай юм. Харин танин мэдэхүй – зан үйлийн онолуудаас чиглэл, аргачлал бага өгдөгөөрөө ялгаатай. Энэ онолын бас нэг чиглэл болох оршин байхуйн онол нь хүний үүрэг хариуцлагаас үүдэн гарах шаналал зовиурыг арилган, амьдралын утга учраа шинэчлэх чөлөөт сонголт хийхэд тусалдаг.

Ерөнхийдөө хүмүүнлэгийн онолын чиглэл нь хүмүүсийг өөрийнхөө хувь заяаны эзэн, түүнийгээ өөрсдөө бүтээдэг, амьдралынхаа хэв маягийг сонгон авч, хөгжүүлдэг, тэгэхдээ нийгмийн болон бусад нөлөөллийг даван гарч чаддаг хэмээн үздэг. Хүмүүнлэгийн онолын томоохон төлөөлөгчид гэвэл Фромм, Олпорт, Келли, Роджерс, Маслоу нар юм. Эдгээрээс А.Маслоу (1908-1970) хамгийн их алдаршсан. Түүний хэрэгцээний шатлалын онол нь ихэд дэлгэрсэн билээ.

Гуманист онолууд нь нийгмийн ажилд дараах зарчмуудыг баримтлахыг шаардана. Үүнд: а) үйлчлүүлэгч ба нийгмийн ажилтны хооронд субъект-субъектийн харилцаатай байх, б) үйлчлүүлэгчид үзүүлж байгаа нөлөөлөл албан ёсны буюу зайлшгүй мэт тулгасан шинжтэй байж болохгүй, в) бие хүнийг “мөнх”-ийн төлөвшин, өөдөлж өсөж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч түүнд хандах, г) үйлчлүүлэгчийн чадвар хөгжиж байдаг хүчин зүйл гэж үзэх зэрэг болно²¹.

Дөрөв. Нэн шинэ үеийн онолууд: Хүний бүхий л зан авирыг тодорхойлох өргөн цар хүрээтэй онол, ерөнхий зарчмуудыг гаргаж ирж болно гэсэн тааврыг үгүйсгэдэг нэн шинэ үеийнхэн харьцангуй үнэн гэж байхгүй, харин тухайн зүйлийг хэрхэн хүлээж авсан талаар ойлголт л байдаг гэж үздэг.

²¹ Payne, (1997) *Modern social work theories*. London

Нэн шинэ үеийн онолд Ерөнхийллийн онол (generative theory), Хүүрнэлийн онол, Нийгмийн конструктив онол, Ёс суртахууны онол, Сүсэг бишрэл ба итгэл үнэмшлийн онол, шүтэлцээний онол зэргийг багтаадаг ба гол төлөөлөгчид нь Салийбэйн (1982), Ван (1979), Виткин (1989), Сипорин (1983), Имри (1989), Канда(1988), Жосеф (1988), Холланд (1989), Шварц (1977)²² нар юм.

Сүүлийн жилүүдэд нэн шинэ үеийн онолын олон хандлага нийгмийн халамж ба нийгмийн ажилд нэвтрэн оржээ. Тэд дараах шинжээрээ нэгдмэл юм. Үүнд:

1. Үйлчлүүлэгч өөрийнхөө амьдралыг хэнээс ч илүү мэднэ гэдгийг хүлээн зөвшөөрч эрх тэгш хамтач харилцаа тогтоох;
2. Үйлчлүүлэгчийнхээ дотоод ертөнц, аж амьдралыг тэдний нүдээр харж ойлгохын тулд онол таамаглалаа бодит байдалд тохируулан дэвшүүлэх;
3. Практик үйлчилгээг үйлчлүүлэгчийнхээ тухай илүү ихийг мэдэх хамтын эрэл хэмээн үзэх.

Нэн шинэ үеийн онолууд нь бодит байдал бол нийгэм, сэтгэлзүйн нөлөөллөөс хамаарна. Хүн гадны сөрөг нөлөөнд автсан, амьдралаа буруу ойлгосноос зовлонд унадаг. Амьдралд өдрөг хандвал зовлонд унахгүй гэж үздэг. Энэ чиглэлийн онолчид хүний хамгийн наад захын амьдралын баталгааг хангаж өгсөнөөр л сайн сайхан амьдрах бололцоо нээгдэнэ гэж үздэг.

Нэн шинэ үеийн онолын төлөөлөгчид “үйлчлүүлэгчээсээ эхэл” гэсэн зарчмыг мөрдлөг болгодог. Энэ нь үйлчлүүлэгчийн хувьсган тусгаж авсан бодит байдлын тухай ойлголтоос ажлаа эхэл гэсэн санаа юм. Гоүлдстэйн “Нийгмийн шинжлэх ухааны орчин үеийн хувилбарууд нь хувь хүн, гэр бүлийн амьдралд тэдний ёс суртахуун, сүсэг бишрэл, зан үйл ихээхэн нөлөөтэйг хүлээн зөвшөөрч сайтар анхаарахыг сануулж байна²³” гэжээ.

Нийгмийн ажилтнууд асуудлыг шийдэх арга замыг сонгохдоо үнэн сэтгэлээсээ хандахгүй бол үйлчлүүлэгчийнхээ цаашид юу болно гэж бодож байгаа, өөрөө юу хийнэ гэж санаж байгаа, яавал дээр байх байсан гэж үзэж байгааг ойлгохгүй. Үйлчлүүлэгчийнхээ амьдралыг ойлгоно гэдэг бол эерэг сөрөг талын баатруудтай, эгзэгтэй сонголт хийх хурц үйл явдалтай жүжиг үзэж байгаатай адил бөгөөд зарим үед өөрөө энэ жүжгийн тодорхой хэсэгт оролцох хэрэг гардаг. Нийгмийн ажилтан ямар тусламж үзүүлэх талаар олон зүйлийг мэддэг, харин үйлчлүүлэгч амьдралынхаа

²² Shulman L, (1993). *Developing and Testing Practice Theory: An Interactional Perspective. Social work, Vol 38*

²³ Horward Goldstein (1990) *The Knowledge Base of Social Work Practice: Theory, Wisdom, Analogui or Art? Families I society, pp. 32-40*

утга зорилгыг тодорхойлох итгэл бишрэл, зан суртахуун, амьдралын үнэт чанар зэргийг багтаасан бодит байдлынхаа талаар хамгийн сайн мэдлэгтэн байдаг. Иймээс хоёулаа хамтраад бэрхшээлтэй асуудлыг шийдэх арга замыг ойлгох, олохын төлөө ажиллах ёстой гэж нэн шинэ үеийн онолчид үздэг.

Нэн шинэ үеийн онол үзэл баримтлалууд нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох асуудалд чухал ач холбогдолтой юм. Манай улсын хувьд нийгмийн халамжийн зорилтот бүлгийг ООТА-р тодорхойлохыг эрмэлзэж байгаа бөгөөд энэ аргачлалд дээрх онолын үзэл баримтлалууд маш чухал гэж үзэж байна. Учир нь нэн шинэ үеийн онолын хандлагууд нь үйлчлүүлэгчийн бодит байдал, үйлчлүүлэгчийн өөрийн үнэлгээ, үйлчлүүлэгчийн дотоод ертөнцийг тэдний нүдээр олж харж ойлгох зэрэгт илүү ач холбогдол өгч байгаа нь ООТА-аар зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалтай илүү нийцэж байгаа хэрэг юм.

ДҮГНЭЛТ

Монголын нийгмийн системийн хувьд нөлөө бүхий томоохон дэд систем бол нийгмийн халамж юм. Гэтэл нийгэмд олон нийтээс эхлээд улс төрчид, бодлого боловсруулагчдыг хүртэл өргөн хүрээнд “Монгол улс халамжийн улс болсон”, “халамж хавтгайрсан”, “бэлэнчлэх сэтгэлгээ газар авлаа” хэмээн шүүмжлэх, үүнээс улбаатайгаар “халамжийг хумих” талаар дээр дооргүй ярьж, бичих болсон байна. Эдгээр шүүмжлэлд үнэний ор буй гэдэгтэй маргахгүй ч, асуудалд илүү нухацтай, шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай байна.

Энэ нөхцөлд нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг их сургуулиуд, судлаачид “ад үзэгдээд” буй халамж хэмээгчийн нийгмийн үүргийг онолын түвшинд хэрхэн тайлбарлагддаг болохыг нэгтгэн дүгнэх, олон нийтэд зөв ойлголт мэдлэг түгээх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна. Нөгөө талаас нийгмийн халамж бол улс төрийн популист амлалтын золиос бус харин нийгмийн бүтэц, системийн чухал хэсэг, эд эс болохыг шинжлэх ухааны онолын түвшинд тайлбарлагддаг болохыг дэлхийн олон судлаач эрдэмтэд баталсаныг ойлгох, халамжийн үйлчилгээг шинжлэх ухааны онолд суурилан хүргэх цаг болсон гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

[1]. Гидденс.А. (2006) Социологи, УБ

[2]. О.Мөнхбат (2016) Нийгмийн ажилд онол хэрэгтэй юу? Социологи сэтгүүл, №11 (456), УБ

[3]. О.Мөнхбат (2008) Социологийн онол, УБ

- [4]. НХТ, НАБСХ (2003), Үйлчлүүлэгчтэй тулж ажиллах практикийг Монголын нийгмийн ажилд томъёолох нь. Нийгмийн Ажлын багш сургагчдын Олон улсын зуны сургалтын материал
- [5]. Merton R. (1957) *Social Theory and Social Structure*. Glencoe
- [6]. Payne, (1997) *Modern social work theories*. London
- [7]. Пинкус А. Минахан А. (1993) *Практика социальной работы (форма и методы)*, Москва.
- [8]. Coady, N. (2001) *Theoretical perspectives for direct social work practice*. Springer Publishing Company, New York, pp. 27-43
- [9]. Shulman L, (1993). *Developing and Testing Practice Theory: An Interactional Perspective*. *Social work, Vol 38*
- [10]. Horward Goldstein (1990) *The Knowledge Base of Social Work Practice: Theory, Wisdom, Analogui or Art? Families I society*, pp. 32-40